



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТАВАНТОЛГОЙ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХХК-ИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/115/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Нямтөмөр
Утас: 261740 Цахим хаяг: nyamtumurl@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн: Шинэ баланс аудит ХХК
Захирал: Б.Мэндбаяр
Утас: 70109154 Цахим хаяг: mendbayar@shinebalans-audit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажилагаа.....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	14
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
8. Аудитын илрүүлэлт	16
8.1 Төлбөрийн акт.....	16
8.2 Албан шаардлага	16
8.3 Зөвлөмж.....	16
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДЭХ	Дулааны эрчим хүч
НББ	Нягтлан бодох бүртгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭХХТ	Эрчим хүчний хөгжлийн төв



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТАВАНТОЛГОЙ ДУЛААНЫ ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ТЭНГЭР ТАНАА

2022.03.15 № 07/562
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол, Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 330.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохимжтой байх, ангилал, оршин байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон зүйл

Техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын 30.0 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК, Эрчим хүчний сайдын 2021 оны А/128 дугаар тушаалаар “Санхүүжилтийн үлдэгдэл 70.0 хувийн эх үүсвэрийг судалж, шийдвэрлэх санал, дүгнэлт боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг Эрчим хүчний яам, Сангийн яам, Хөгжлийн банк, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-ийн бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Ажлын хэсэг нь төслийн 70.0 хувийн эх үүсвэрийг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд санхүүжилтийн шийдэлд олон талт хувилбар боловсруулж, төслийн санхүүжилтийн хэлбэрийг санал болгосноор холбогдох шийдвэрүүд гарч 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр ЭХТ-001/20 дугаар төслийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг олон улсад нээлттэй зарласан байна. Тус олон улсын нээлттэй тендер нь 2022 оны 03 дугаар сарын 16-ний өдөр нээлт хийхээр төлөвлөгджээ.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Эрчим хүчний сайдын 2021 А/127 дугаар тушаалаар 2021 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинд үйл ажиллагааны санхүүжилтийг 5,407.3 сая төгрөгөөр, зардлыг 3,573.7 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтыг 1,833.6 сая төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр 5,692.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгогдож, 2,817.3 сая төгрөгийн зардал гарган, 1,465.1 сая төгрөгийг хөрөнгө оруулалтад зарцуулжээ.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус компани нь тайлант онд нийт 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний 26 ажлыг төлөвлөснөөс 10 ажил хэрэгжиж, гүйцэтгэлийг 87.0 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	853,637,651.58	2,803,025,099.44
1.1.02	Дансны авлага	2,560,000.00	199,197,799.75
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	624,117.31	13,870,147.07
1.1.06	Бараа материал	2,805,522.60	139,547,436.45
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	14,628,344,993.41	14,876,344,270.65
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	15,487,972,284.90	18,031,984,753.36
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.01	Үндсэн хөрөнгө	176,061,944.72	1,273,504,133.17
1.2.02	Биет бус хөрөнгө	-	12,127,500.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	176,061,944.72	1,285,631,633.17
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,664,034,229.62	19,317,616,386.53
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1.01	Дансны өглөг	-	9,642,794.00
2.1.1.02	Цалингийн өглөг	-	2,532,438.59
2.1.1.03	Татварын өр	11,973.00	1,339,588.70
2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	3,486,229.47
2.1.1.06	Хүүний өглөг	811,690,674.17	3,432,667,798.87
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	402,075,309.94	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,213,777,957.11	3,449,668,849.63
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.01	Урт хугацаат зээл	42,219,055,387.01	42,208,535,848.80
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	478,077.78	660,574.44
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	42,219,533,464.79	42,209,196,423.24
2.2	Өр төлбөрийн нийт дүн	43,433,311,421.90	45,658,865,272.87
2.3	Эздийн өмч		
2.3.01	Өмч: - төрийн	20,000.00	20,000.00
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	-	5,858,696,244.72
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(27,769,297,192.28)	(32,199,965,131.06)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(4,264,585,994.06)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(27,769,297,192.28)	(27,935,379,137.00)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(27,769,277,192.28)	(26,341,248,886.34)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	15,664,034,229.62	19,317,616,386.53

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмнөх үеийн	Тайлант үеийн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг(алдагдал)	-	-
4	Түрээсийн орлого	-	-

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	657,363,152.37	526,218,474.89
8.1	Орлогын дүн	657,363,152.37	526,218,474.89
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	196,794,421.50	2,051,190,998.46
11	Санхүүгийн зардал	459,718,600.57	2,621,445,527.17
12	Бусад зардал	27,817,465,050.03	44,321,736.24
12.1	Зардлын дүн	28,473,978,072.10	4,716,958,261.87
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	47,807,778.23	10,711,289.58
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(84,375,000.00)
17.1	Олз, гарзын дүн	47,807,778.23	(73,663,710.42)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(27,768,807,141.50)	(4,264,403,497.40)
19	Орлогын татварын зардал	490,050.78	182,496.66
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(27,769,297,192.28)	(4,264,585,994.06)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(27,769,297,192.28)	(4,264,585,994.06)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	-	-	-	-
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(27,769,297,192.28)	(27,769,297,192.28)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	20,000.00	-	-	20,000.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2020 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	20,000.00	-	(27,769,297,192.28)	(27,769,277,192.28)
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	166,081,944.72	(166,081,944.72)	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(4,264,585,994.06)	(4,264,585,994.06)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	5,692,614,300.00	-	5,692,614,300.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	20,000.00	5,858,696,244.72	(32,199,965,131.06)	(26,341,248,886.34)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
№	Үзүүлэлт	Өмнөх үеийн	Тайлант үеийн	
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,056,358,462.31	158,811,669.52	
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-	
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-	
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	4,069,020.00	
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-	
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-	
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,056,358,462.31	154,742,649.52	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	191,372,361.23	2,462,751,016.56	
1.2.1	Ажиллагчдад төлсөн	93,364,686.59	899,246,636.49	
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	24,446,245.71	229,160,737.65	
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	9,542,340.00	193,180,750.09	
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	-	
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,388,900.00	80,686,475.33	
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	14,715,282.20	109,336,287.45	
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	28,220,242.60	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	46,914,906.73	922,919,886.95	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	864,986,101.08	(2,303,939,347.04)	
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-	
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	129,958.06	-	
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-	
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-	
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-	
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-	
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	109,958.06	-	
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	-	
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-	
2.1.8	Бусад	20,000.00	-	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,980,000.00	1,439,010,854.00	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,980,000.00	1,424,160,854.00	
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	14,850,000.00	
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-	
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-	
2.2.6	Бусад	-	-	

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,850,041.94)	(1,439,010,854.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	15.14	5,692,773,845.12
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	5,692,614,300.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	15.14	159,545.12
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,498,422.70	436,196.22
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад	1,498,422.70	436,196.22
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,498,407.56)	5,692,337,648.90
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	853,637,651.58	1,949,387,447.86
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	853,637,651.58
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	853,637,651.58	2,803,025,099.44

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
I.	Удирдлагын зардал	126,990,910.33	1,794,424,097.50	1,214,847,292.83	579,576,804.67	67.70
1	Цалин хөлс	112,973,014.43	1,569,111,717.50	1,091,026,939.47	478,084,778.03	69.53
2	Нийгмийн даатгалын шимгэл ХХОАТ	14,017,895.90	225,312,380.00	123,820,353.36	101,492,026.64	54.95
Томилолт:		2,318,377.40	113,302,570.00	16,177,174.30	97,125,395.70	14.28
1	Дотоод томилолтын зардал: хоол байр, шатахуун	-	113,302,570.00	16,177,174.30	97,125,395.70	14.28
2	Хот доторх албан хэрэгцээнд	1,218,377.40	-	-	-	-
3	Компанийн лого	1,100,000.00	-	-	-	-
Сургалт:		3,300,280.00	102,653,240.00	96,862,047.00	5,791,193.00	94.36
1	Ажилчдын чадвар хөгжүүлэх сургалт, семинар багаар	-	75,653,240.00	74,697,838.00	955,402.00	98.74
1	Бичиг хэргийн материал, хэрэгсэл	3,300,280.00	27,000,000.00	22,164,209.00	4,835,791.00	82.09

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

II.	Үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд	55,410,065.23	1,541,495,552.50	1,489,390,282.49	52,105,270.01	96.62
1	Түрээс	43,141,782.00	151,920,000.00	151,819,280.53	100,719.47	99.93
2	Машины зогсоол		30,520,000.00	15,858,666.67	14,661,333.33	51.96
3	Шуудан холбоо, интернет	1,132,503.23	17,100,000.00	9,070,307.72	8,029,692.28	53.04
4	Автомашин засвар	1,268,500.00	20,000,000.00	14,380,235.00	5,619,765.00	71.90
5	Ашиглалтын зардал		126,600,000.00	126,583,157.07	16,842.93	99.99
6	Цэвэрлэгээний материал	2,500,000.00	4,665,000.00	3,302,999.00	1,362,001.00	70.80
7	Санхүүгийн программ	-	14,850,000.00	14,850,000.00	-	100.00
8	Бусад	4,994,780.00	1,103,833,552.50	1,103,833,552.50	-	100.00
9	Аудитын төлбөр	1,500,000.00	25,000,000.00	8,677,314.00	16,322,686.00	34.71
10	Ковид-19 урьдчилан сэргийлэх зардал	872,500.00	47,007,000.00	41,014,770.00	5,992,230.00	87.25
Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн		9,980,000.00	3,551,875,460.00	2,817,276,796.62	734,598,663.38	79.32
III.	Контор засвар	0.00	21,800,000.00	18,944,948.00	2,855,052.00	86.90
IV.	Эд хогшил худалдан авах	9,980,000.00	1,833,638,800.00	1,446,157,651.18	387,481,148.82	78.87
Нийт зардлын дүн		197,999,632.96	5,407,314,260.00	3,818,745,560.32	1,588,568,699.68	70.62

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөхөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол мэдээлж байх талаар, тендерийн бичиг баримтыг хуулийн дагуу боловсруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 14-нөөс 2022 оны 03 дугаар сарын 09-ний хооронд Шинэ баланс аудит ХХК-ийн аудитор Г.Гантуяа, аудиторын туслах Ц.Болортуяа, Ш.Жавзанпагма, С.Цэрэндаш нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Б.Мэндбаяр хэрэгжүүлсэн.

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч тус байгууллагын ашиглалтын өмнөх үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 1.2-т “Төслийн санхүүжилт, цахилгаан станцын бүтээн байгуулалтын үеийн өртөг зардал тооцолт зэрэг асуудлуудыг хамарна” гэж заасан боловч ашиглалтын өмнөх үеийн зардлын санхүүжилт, хэрэгжүүлэх төсөлтэй холбоотой гарах зардлын бүртгэл тодорхойгүй байна.

Тайлант онд Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тус компанийн 2020, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах үйл ажиллагаанд аудит хийж, Эрчим хүчний сайд 2021 оны а/4045 дугаар бүхий албан бичгээр шалгалтын тайланг хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлын тайлантай танилцаж, худалдан авах ажиллагаатай холбоотой материалыг аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох суурь үзүүлэлтийг орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөх үе шатанд материаллаг байдлыг тооцохдоо 2020 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсон ба 2021 оны санхүүгийн тайлангаарх орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 4,716.9 сая төгрөг болж өссөн тул гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзлээ.

Гүйцэтгэлийн материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1.5 хувиар 70.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн зорилгыг “450мвт-ын дулааны цахилгаан станц төслийг 2020-2024 онд багтаан чанартай, бүрэн хэрэгжүүлж, түлхүүр гардуулах нөхцөлөөр станцыг барьж ашиглалтад оруулснаар Өмнийн бүсийн уул уурхай болон Оюутолгой төслийн эрчим хүчний хэрэгцээг найдвартай бүрэн хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Санхүүжилтийн нөхцөлийг тодорхойлж шийдвэрлүүлэх, санхүүжилтийн эргэн төлөлтийг хариуцах;
- Барилгын ажлын захиалагчийн үүргийг гүйцэтгэж, хяналт тавьж, ашиглалтад оруулах;
- Станцын үйл ажиллагааг эрхлэн явуулж, цахилгаан үйлдвэрлэн Оюутолгой болон бусад Өмнийн говийн уул уурхайн төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг хангах.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн статустай байна. Өмчийн 70.0 хувийг төр, үүнээс 51.0 хувийг Эрчим хүчний яам, 19.0 хувийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, 30.0 хувийг Эрдэнэс тавантолгой ХК тус тус эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн Газар 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр “Тавантолгой цахилгааны станцын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 124 дүгээр тогтоол гаргаж, уг тогтоолоор төсөл хэрэгжүүлэх зорилгоор Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-ийг 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг

байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 01 дүгээр тогтоолоор, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 05 дугаар тогтоолоор 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох” гэсэн заалттай нийцэж байна.

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг 199.0 сая төгрөгөөр тогтоосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “... цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд өмнөх төслийн нэгжийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан 161,081.9 мянган төгрөгийн үлдэх өртөг бүхий хөрөнгийг шилжүүлэн авч, өмчийн бусад хэсэгт бүртгэх тухай саналаа ТӨБЗГ-т тавьж шийдвэрлүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн Газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамт/тариф/-ын хэлэлцээр;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	853,637.7	2,803,025.1	1,949,387.4
Дансны авлага	2,560.0	199,197.8	196,637.8
Татвар, НДШ-ийн авлага	624.1	13,870.1	13,246.0
Бараа материал	2,805.5	139,547.4	136,741.9
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	14,628,345.0	14,876,344.3	247,999.3
Үндсэн хөрөнгө	176,061.9	1,273,504.1	1,097,442.2
Биет бус хөрөнгө	-	12,127.5	12,127.5
Нийт хөрөнгийн дүн	15,664,034.2	19,317,616.4	3,653,582.2
Өр төлбөрийн дүн	43,433,311.4	45,658,865.3	2,225,553.9
Богино хугацаат өглөг	1,213,778.0	3,449,668.8	2,235,890.9

Урт хугацаат өглөг	42,219,533.5	42,209,196.4	(10,337.0)
Эздийн өмч	(27,769,277.2)	(26,341,248.9)	1,428,028.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,664,034.2	19,317,616.4	3,653,582.2

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 6.8 сая, арилжааны банк дахь харилцах дансанд 245.7 сая, Хөгжлийн банкны зээлийн дансанд 550.4 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд НӨАТ-ын авлага 6.8 сая төгрөг, байгууллагаас авах авлага 199.2 сая төгрөг байна.

Тайлант онд хил хаагдсантай холбоотой Монтех дистрибьюшн ХХК барааг хугацаанд нийлүүлж чадаагүйгээс 198.2 сая төгрөгөөр авлага нэмэгдсэн байна.

Урьдчилж гарсан зардал дансны 14,628.3 сая төгрөг нь өмнөх төслийн нэгжээс шилжиж ирсэн үлдэгдэл бөгөөд уг урьдчилгаа төлбөр нь 2013-2017 онуудад ТЭЗҮ, зураг төсөл, усны нөөц хангамжийн судалгаа, нүүрсний шинжилгээ, олон улсын хууль эрх, санхүүгийн болон техникийн зөвлөх үйлчилгээ, геологи, геодезийн судалгаа, кадастрын судалгаа зэрэг ажлын зардлыг хуримтлуулан бүртгэсэн, 208.1 сая төгрөг нь тайлант онд үүссэн бөгөөд тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж болон үйлчилгээний хөлс, санхүүгийн, хуулийн зөвлөх үйлчилгээний төлбөрийг бүртгэсэн ба цаашид цахилгаан станцын өртөгт шингэх зардал байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 139.5 сая төгрөг болж 136.7 сая төгрөгөөр өссөн нь албан хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай хангамжийн материал худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 1,283.6 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны А-1/861 дүгээр тогтоолоор акталсан 44.6 сая, 317 дугаар тогтоолоор балансаас баланст шилжүүлсэн 170.4 сая төгрөгийн дүнгээр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө шинээр худалдаж авсан 12.1 сая төгрөгийн санхүүгийн программын дүнгээр өсжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд цалингийн өглөг 2.5 сая төгрөг, ХХОАТ-ын өр 1.3 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 3.5 сая төгрөг, Хөгжлийн банкны урт хугацаат зээлийн хүүний өглөг 3,432.7 сая төгрөг, нийт 3,449.7 сая төгрөгийн өр төлбөр байна.

Өмнө нь хэрэгжиж байсан төслийн нэгж нь Хөгжлийн банкнаас 2014 онд 15.9 сая ам.доллар буюу 27,537.0 сая төгрөг (тухайн үеийн ам.долларын ханш 1,727.22)-ийн зээлийг Засгийн газрын 2013 оны 80 дугаар тогтоолд заасан Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн 450мвт хүчин чадалтай цахилгаан станц барих, ашиглалтад оруулахтай холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай авч, зээлийг 2013-2017 онуудад ТЭЗҮ, зураг төсөл, усны нөөц хангамжийн судалгаа, нүүрсний шинжилгээ, олон улсын хууль эрх зүй, санхүүгийн болон техникийн зөвлөх үйлчилгээ, геологи, геодезийн судалгаа, кадастрын судалгаа зэрэг ажлын зардлын санхүүжилтэд зарцуулсан ба 1.1 сая ам.долларын зээлийг төлж, зээлийн үлдэгдэл 14.8 сая ам.доллар буюу 42,208.5 сая төгрөг байна.

Хөгжлийн банкнаас авсан зээл төлөгдөхгүй байгаа нь төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах гэрээнд заасан зээлдэгчийн эрх үүргийг Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-д шилжүүлээгүй, гэрээний эрх үүргийг шинэчлээгүй, мөн эргэн төлөх эх үүсвэр шийдвэрлэгдээгүйгээс зээл төлөгдөхгүй байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлыг эдийн засгийн үр ашгийн бууралт нь хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлж байгаа бөгөөд хэмжиж болохуйц байвал зардлыг хүлээн зөвшөөрч, төлсөн, эсвэл төлөхөөр

хүлээгдэж байгаа мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнээр хэмжинэ гэж заасан байна.

Санхүүгийн тайланд ерөнхий удирдлагын зардал, санхүүгийн зардал, бусад зардал гэж ангилсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу удирдлага нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Эрчим хүчний сайдын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/127 дугаар тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг 61.6 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Тайлант оны зардлын санхүүжилтийг 5,407.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 3,573.7 сая төгрөгөөр баталсан ба үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,833.6 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2,817.3 сая төгрөгийн зардал гарган, 1,465.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 1,588.7 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК нь тайлант онд нийт 117,14.8 сая төгрөгийн 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5.0 сая төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөгжлийн банктай 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр З-ДЦ-Б 2014-30 дугаар бүхий "Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай" 14,816,251.00 ам.долларын зээлийн гэрээг Эдийн засгийн хөгжлийн яам, Эрчим хүчний яам байгуулсан байна. Тус зээл нь Эрчим хүчний сайдын 2020 оны 166 дугаар тушаалаар өмнөх төслөөс тус компанийн баланст шилжүүлэн бүртгэсэн байна. Гурван талт гэрээг дүгнээгүй, ЭХЯ болон ТӨБЗГ-с зээлийн эргэн төлөлтийг хэрхэн шийдвэрлэх, гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг бүрэн хангуулах талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 42 дугаар тогтоолоор "Гурван талт зээлийн гэрээг дүгнэж, эрх үүргийг шилжүүлэн авах, эсхүл дуусгавар болох ажлыг зохион байгуулж, чиг үүргийн дагуу Эрчим хүчний сайд болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран уг төслийн зээлийн эргэн төлөлтийг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авах, гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах, хэрэгжилтийг бүрэн хангуулж, холбогдох арга хэмжээг авах" зэрэг заалтад нийцэхгүй зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Тус компани нь Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 02 дугаар тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн хурлын зардлыг 60.2 сая төгрөгөөр батлахдаа хувьцаа эзэмшигчдэд 51.4 сая төгрөгийн цалин олгохоор баталсан байна. Тогтоолын дагуу тайлант жилд ТУЗ-ын төрийн төлөөллийг хэрэгжүүлж буй 5 гишүүнд 20.2 сая төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 "Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах", Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолын 3.7 "Цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-д албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль, зээлийн эрх үүргийг шилжүүлээгүй нь Засгийн газрын 42 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 382.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 20.2 сая төгрөгийг залруулж, 196.8 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 165.5 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 0.3 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгснөөс төлбөрийн актын биелэлт 100.0 хувь, 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	0.7	1	0.7	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	4	0.3	3	0.3	1	-	0
Нийт дүн	5	1.0	4	1.0	1	-	0

Хөгжлийн банкны зээлийн гэрээг дүгнэж, эргэн төлөлтийг шийдвэрлэх талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтан гарсан тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Хөгжлийн банкнаас авсан зээлийн ашиглалт, зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн эсэх, Засгийн газрын 2017 оны 42 дугаар тогтоолын хэрэгжилт, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн явцыг шалгана.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 305.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт, 22.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 279.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 305.1 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 70.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

8.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд ТУЗ-ийн гишүүдэд цалин урамшууллыг тогтоосон хэмжээнээс 3.6 сая төгрөгөөр илүү олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7 "Энэ журмын 3.6-д заасан цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

8.2 Албан шаардлага

Компанийн үйл ажиллагаа жигдрээгүй, үйл ажиллагааны орлогогүй, хөрөнгө оруулагч компаниас санхүүжилтээр үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг, 2020 онд 3 сар үйл ажиллагаа явуулсан байхад компанийн ТУЗ-ийн шийдвэрээр удирдах ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 22.5 сая төгрөгийн дэмжлэг, сар бүр үндсэн цалингаас гадна нэмэгдэл олгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 “Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах”, мөн хуулийн 21.6 “Төрийн өмчийн төлөөлөгч болон төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана. Удирдамж, зааврыг зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй нь түүнийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-д албан шаардлага хүргүүлэв.

8.3 Зөвлөмж

Худалдан авах ажиллагаатай холбоотой

1.1 Илрүүлэлт:

Эрчим хүчний сайдын 2021 оны А/127 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд технологийн зориулалттай аюулгүй ажиллагаа хангасан тээврийн хэрэгслийг 279.0 сая төгрөгөөр худалдан авахаар тусгасан. Гэтэл компани зориулалтыг өөрчлөн НТШ№21/13 дугаар бүхий гэрээгээр Моннис мотор ХХК-иас худалдан авсан ба Ниссан патрол У62 суудлын автомашинд технологийн тусгай багажууд нь суурилагдаагүй байна.

Энэ нь ТБОНӨХБҮХАТ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 “Тухайн бараа, ажил, үйлчилгээг гадаад шинж чанарын үзүүлэлтээр бус, зориулалт, эрчим хүч, байгалийн нөөцийн

хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээ, ашиглалт, чанарын түвшин, техникийн болон тухайн бараа, ажил, үйлчилгээ нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлох” гэсэн заалтыг мөрдөөгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Бараа худалдан авах тендерийн жишиг баримтад техникийн тодорхойлолтыг зөв боловсруулах, барааг хүлээж авахдаа техникийн тодорхойлолтыг хангаж байгаа эсэхийг үнэлж байх.

2.1 Илрүүлэлт:

Компанийн Үнэлгээний хорооны гишүүд тендерийн баримт бичгийг боловсруулахдаа Үнэлгээний хорооны зөвлөмжийг буруу боловсруулсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.2 "Үнэлгээний хороо тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх", 47 дугаар зүйл 47.2 "Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна: 47.2.1.техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх; 47.2.2.тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх. Уг шийдвэрийг энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан үндэслэлгүйгээр өөрчлөхийг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Тендерийн материалыг Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан "Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг"-ийн дагуу боловсруулж ажиллах.

3.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд хөрөнгийг зориулалт тус бүрээр данс үүсгэж, дансны ангиллыг буруу сонгож, бүлгээр бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааврыг мөрдөөгүй, мөн ангилал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийг шинж чанараар нь бүлэглэж, бүлгээр бүртгэж, тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Тавантолгойн дулааны цахилгаан станц ТӨХХК	АХГ-2022/115/НА-СТА-ТӨА	Компани нь тайлант хугацаанд ТУЗ-ийн гишүүдэд 3,600.0 мянган төгрөгийн цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс хэтрүүлж олгосон байна.	Төлбөрийн акт	1	3,600.0	-	-	1	3,600.0	-	-	-	-	-	-
2	Тавантолгойн дулааны цахилгаан станц ТӨХХК	АХГ-2022/115/НА-СТА-ТӨА	Компанийн үйл ажиллагаа жигдрээгүй, үйл ажиллагааны орлогогүй, хөрөнгө оруулагч компаниас санхүүжилтээр үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг, 2020 онд 3 сар үйл ажиллагаа явуулсан компанийн ТУЗ 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 13 дугаар тогтоолоор контракт гэрээний биелэлтийг “Хангалттай” гэж үнэлэн Гүйцэтгэх захиралд ТУЗ-тэй байгуулсан контрактын 4.5 дах хэсэгт заасны дагуу нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний 22.5 сая төгрөгийн дэмжлэг олгосон, мөн сар бүр үндсэн цалингийн 60.0 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл олгосон байна.	Албан шаардлага	1	22,500.0	-	-	-	-	1	22,500.0	-	-	-	-

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	Тавантолгойн дулааны цахилгаан станц ТӨХХК	АХГ-2022/115/НА-СТА-ТӨА	Компанийн үнэлгээний хорооны гишүүд тендерийн баримт бичгийг хууль болон Сангийн яамнаас гаргасан жишиг баримт бичгийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй байна.	Үнэлгээний хорооны гишүүдийн ажлын хариуцлагыг дээшлүүлэх, дотоод хяналтыг сайжруулах.	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
4	Тавантолгойн дулааны цахилгаан станц ТӨХХК	АХГ-2022/115/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд хөрөнгийг зориулалт тус бүрээр дан үүсгэж, дансны ангиллыг буруу сонгож, бүлгээр бүртгээгүй байна.	Үндсэн хөрөнгийг шинж чанараар нь бүлэглэж, бүлгээр бүртгэж, тайлагнах	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
5	Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК	АХГ-2022/11/5/НА-СТА-ТӨА	Моннис мотор ХХК-иас НТШ№21/13 дугаар бүхий гэрээгээр 10 сард Ниссан патрол У62 суудлын автомашиныг 279,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан бөгөөд машинд тусгай багаж нь суурилагдаагүй байна.	Бараа худалдан авах тендерийн жишиг баримтад техникийн тодорхойлолтыг зөв боловсруулах, барааг хүлээж авахдаа техникийн тодорхойлолтыг хангаж байгаа эсэхийг үнэлэх.	1	279,000.0	-	-	-	-	-	-	-	-	1	279,000.0
ДҮН					5	305,100.0	-	-	1	3,600.0	1	22,500.0	-	-	3	279,000.0
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																

Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	Тавантолгойн дулааны цахилгаан станц ТӨХХК	АХГ-2022/115/НА-СТА-ТӨА	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5.0 сая төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	5,012.9								1	5,012.9	
2	Тавантолгойн дулааны цахилгаан станц ТӨХХК	АХГ-2022/115/НА-СТА-ТӨА	Хөгжлийн банк 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр 3-ДЦ-Б 2014-30 дугаар бүхий "Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай" 14,816,251.00 ам.долларын зээлийн гэрээг Эдийн засгийн хөгжлийн яам, Эрчим хүчний яамтай байгуулсан байна. Тус зээл нь Эрчим хүчний сайдын 2020 оны 166 дугаар тушаалаар өмнөх төслөөс тус компанийн балансад шилжиж ирсэн байна	Албан шаардлага	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	
3	Тавантолгойн дулааны цахилгаан станц ТӨХХК	АХГ-2022/115/НА-СТА-ТӨА	Тус компани нь Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 02 дугаар тогтоолоор компанийн ТУЗ-д төлөөллийг хэрэгжүүлж буй хувьцаа эзэмшигч 5 гишүүнийн цалин, зардлыг 60,204.5 мянган төгрөгөөр баталж, тайлант жилд 20,160.0 мянган төгрөгийн цалин олгосон нь үйл ажиллагааны зардлыг төсвөөс санхүүжүүлдэг компанийн хувьд тохиромжгүй байна.	ТУЗ-д албан шаардлага	1	20,160.0	-	-	-	-	1	20,160.0	-	-	-	
			ДҮН		3	25,172.9	-	-	-	-	1	20,160.0	-	-	1	5,012.9
			НИЙТ ДҮН		7	330,272.9	-	-	1	3,600.0	3	42,660.0	-	-	4	284,012.9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 83/А0150055
АХГ-2022/115/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөл бүрэн эрхийнхээ хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний цалинг өндөр тогтоон, 3,600,000.00 төгрөгийн урамшуулал илүү олгосон, ашиглалтын өмнөх зардлыг хэмнэх бодлого баримтлаагүй, 2 нарийн бичгийн даргатай байна.


Энэ нь Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7 "Энэ журмын 3.6-д заасан цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 3,600,000.00 төгрөгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээр төлүүлэн, Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Насантогтох, захирал Г.Тэнгэр нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОРЫН МЕНЕЖЕР
ШИНЭ БАЛАНС АУДИ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц. ХОСЖАРГАЛ

Б.МЭНДБАЯР

'001090227



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 412/АО/0055

Улаанбаатар хот

АХГ-2022/115/НБ-СТБ-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Компанийн үйл ажиллагаа жигдрээгүй, үйл ажиллагааны орлогогүй, хөрөнгө оруулагч компаниар үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг, 2020 онд 3 сар үйл ажиллагаа явуулсан байхад компанийн ТУЗ-ийн тогтоолоор удирдах ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 22.5 сая төгрөгийн дэмжлэг, сар бүр үндсэн цалингаас гадна нэмэгдэл олгосон, Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор ТУЗ-ийн төрийн төлөөллийг хэрэгжүүлж буй хувьцаа эзэмшигч 5 гишүүнд цалин олгох шийдвэр гаргаж, тайлант жилд 20.2 сая төгрөгийн цалин олгосон.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 "Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах", мөн хуулийн 21.6 "Төрийн өмчийн төлөөлөгч болон төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана. Удирдамж, зааврыг зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй нь түүнийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулж байх", Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7 "Энэ журмын 3.6-д заасан цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлөөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Компанийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төрийн өмчийн төлөөлөгч болон төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүд, компанийн удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоох, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэрийг гаргахдаа компанийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад чиглүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Насантогтоход хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ШИНЭ БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц НАРАНЧИМЭГ
Ц ХОСЖАРГАЛ
Б.МЭНДБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 411/A0150055
АХГ-2022/115/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөгжлийн банкны 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр З-ДЦ-Б 2014-30 дугаар бүхий "Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай" 14,816,251.00 ам.долларын зээлийн гэрээг Эдийн засгийн хөгжлийн яам, Эрчим хүчний яамтай байгуулсанг Гурван талт гэрээг дүгнээгүй, ЭХЯ болон ТӨБЗГ-с зээлийн эргэн төлөлтийг хэрхэн шийдвэрлэх, гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг бүрэн хангуулах талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 42 дугаар тогтоолын "Гурван талт зээлийн гэрээг дүгнэж, эрх үүргийг шилжүүлэн авах, эсхүл дуусгавар болох ажлыг зохион байгуулж, чиг үүргийн дагуу Эрчим хүчний сайд болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран уг төслийн зээлийн эргэн төлөлтийг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авах, гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах, хэрэгжилтийг бүрэн хангуулж, холбогдох арга хэмжээг авах" зэрэг заалтад нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тус компанийн зээлийн гэрээнд оролцогч талыг тодорхой болгох асуудлыг шийдвэрлэх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
1. Зээлдэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Жанарбаатар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ШИНЭ БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

(Handwritten signatures)

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Б.МЭНДБАЯР

9006109
9019120396